

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь 2023.01.03-ны 11 цагт Засаг даргын тамгын газрын хурлын өрөөнд ТУЗ-н дарга Б. Гүррагчаагаар ахлуулан хийлээ. Хурлын бүрэлдэхүүнд:

- Зөвлөлийн дарга Б. Гүррагчаа
- Зөвлөлийн гишүүн Т. Болдбаяр .
- Зөвлөлийн нарийн бичиг Г.Насанжаргал нар оролцов.

Зөвлөлийн гишүүн шахмал түлшний ажилтан н. Түвшинтулга, Зөвлөлийн гишүүн шахмал түлшний ажилтан Дондов гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй. Үүнээс 3 гишүүн нь ирсэн учраас ирц 60% хүчин төгөлдөр гэж үзээд ТУЗ-ийнхөө хурлаа эхлүүлье. Мөн тохижилт үйлчилгээний дарга Д. Ганцоож, ИТХурлын дарга Б. Ганбаяр нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Тохижилт үйлчилгээний албаны бүтэц орон тоо
- Ажилчдын цалин хөлс
- Олон нийтийн хог хаягдлын хураамжийн байцаагч орон тоо үүсгэн авах талаар

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нарийн бичиг Г. Насанжаргал- байгууллагын дотоод үйл ажиллагааны талаар тулгамдаад буй хүндрэлийн талаар тайлан тавив.

Манай алба нь Тосонцэнгэл сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг технологийн дагуу хөрсөөр дарж булах, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, тохижуулалт, цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлт, нийтийн эзэмшлийн гудамж, авто зам, явган зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилт, арчлалт, эзэнгүй нохой устгалыг хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэйгээр 9 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны онцлог, машин техник хэрэгслийн эвдрэл гэмтэл их, өдөр тутмын үйл ажиллагааны зардал өндөр, орлого бага зэргээс шалтгаалан байгууллагын санхүүгийн болон өдөр тутмын үйл ажиллагаанд дараах хүндрэлүүд үүсээд байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн нөхцөлд таарсан, жишиг цалин хангамжийг ажилчдад олгох санхүүгийн чадамжгүй, ажилчдын нийгмийн байдал хангагдаагүй. - Нийт ажилчдын дийлэнх хувийг хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээгээр цалинжуулан, нэмэгдэл цалин, хуульд заагдсан бусад нэмэгдлийг огт олгож байгаагүй. Өнөөдрийн байдлаар байгууллагын дундаж цалин 467.000 төгрөг бөгөөд гар дээрээ 392.000 төгрөгний цалин авч байна. Цаашид ажилчдын цалин хөлсийг эдийн засгийн үзүүлэлт, инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэх, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн ажилчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг хуулийн дагуу бүрэн олгоход байгууллагын бусад үйл ажиллагааны зардал хойшлогдон өр төлбөрийн хуримтлал үүсч хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй. Ажилчдын ажлын ачаалал, чадамжийг үндэслэн ажил үүргийг хавсруулан гүйцэтгүүлэх буюу хамгийн бага орон тоогоор /норм дүрмийг баримтлах боломжгүй/ ажиллаж байна. Санхүүгийн чадамж муутайгаас ажилчдад хуулийн дагуу олгох нэмэгдлүүдийг олгодоггүй, тогтмол цалингаар цалинждаг.

2. **Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны зардал өндөр, үйл ажиллагааны орлого бага** – Байгууллагын өмчлөлийн хэлбэрээс шалтгаалан МУЗГ-аас гаргаж буй аливаа хөнгөлөлт, урамшуулал, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрт /ковидын үеийн/ огт хамрагдаагүй, машин техник хэрэгслийн засвар үйлчилгээ, зам арчилгаа, гудамжны гэрэлтүүлэг, нохой устгалын ажил зэрэг нь үйл ажиллагааны өндөр зардалтай бөгөөд эдгээр ажлыг өөрийн дотоодын орлогоос гүйцэтгэх ямар ч боломжгүй учир шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн өр төлбөр ихээр үүсдэг. Дээрх үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах гол түүхий эд шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл болон бусад бараа материалын үнэ өсөн нэмэгдсэн нь үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй нөхцөлд хүргэж байна.

Дарга: Д. Ганцоож – Хог хаягдлын хураамжийн татвар өссөнтэй холбоотойгоор Хог хаягдлын байцаагч авч аж ахуй нэгж албан байгууллага, айл өрхөөр явж хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх шаардлагатай байна.

ТУЗ-н Дарга: Д. Гүррагчаа - Бүтэц орон тоог одоо байгаагаар нь баталж, ажилчдын цалин хөлсийг анхаарах хэрэгтэй байна. Ажиллах нөхцөл хүнд бохир хог хаягдал ачиж тээвэрлэн ажилладаг учир цалин хөлс муутайгаас болж ажиллах хүч хомс, олдохгүй байна. Иймд орлогоо нэмэгдүүлэн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан үе шаттайгаар ажилчдын цалинг нэмэх талаар арга хэмжээ авч ажиллана. Сарл орж ирэх санхүүжилтэнд тааруулж үйл ажиллагаанд гарах зардалаа өөрийн орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллан өр үүсгэхгүй ажиллах шаардлагатайг анхаарч ажиллах хэрэгтэй.

Хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэхэд болон орлогоо нэмэгдүүлэхэд байцаагчийн орон тоог нэмэх нь зүйтэй гэж үзэж байна. Хог хаягдлын байцаагчийг орон тоо давхцуулахгүйгээр томилж, жилийн хугацаатайгаар гэрээт ажилтан авч ажиллуулах. Хог хаягдлын хураамж нь төрийн санд төвлөрөх ба татварын мөнгийг хуримтлуулж, үлдсэн хураамжийг тус албаны үйл ажиллагаанд зарцуулахад хэрэгтэй үзэж байна

ИТХурлын дарга: Б. Ганбаяр –ИТХурлын шийдвэрээр зориулалтын хог хаягдлын машин авах 80,000,000 / наян сая төгрөг/ -өөр авах шийдвэр гарч тендер нь 03 сард явагдах тул ажлын даалгавараа маш сайн хийж илүү төсөв гарвал 2 машин авах талаар эдийн засгийн болон үнийн судалгааг хийж саналаа төрийн сангийн нягтлан Гэрэлмаад өгөх. Нохой устгалын зардал нь орон нутгийн төсөвөөс жилд 5000,000 / таван сая төгрөг/- өөр хийх иргэдийн төлөөлөгчдийн хурлаас шийдвэр гарсан.

ИТХурал болон Орон нутгийн хөгжлийн сангаас дэмжиж ажиллах учраас байцаагчийг томилон ажилд авах.

Хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэхэд болон орлогоо нэмэгдүүлэхэд байцаагчийн орон тоог нэмэх нь зүйтэй гэж үзэж байна. Хог хаягдлын хураамж нь төрийн санд төвлөрөх ба татварын мөнгийг хуримтлуулж, үлдсэн хураамжийг тус албаны үйл ажиллагаанд зарцуулах болно.

ТУЗ-н гишүүн: Болдбаатар – Зах зээлийн үнийн судалгааг сайн хийж чанар сайтай хямдаар машин авч тулгараад байгаа ковшийн 2-4 ширхэг дугуйг шийдвэрүүлээд авбал манай байгууллагад хэрэгтэй санагдаж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

ТУЗ-н Дарга: Б. Гүррагчаа- 2023 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөгдөх хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээ 550,000 / таван зуун тавин мянган төгрөг/ болж байгаатай уялдуулан нийт ажилчдын цалин хөлсийг тус бүр 100,000 / нэг зуун мянган төгрөг/- өөр нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа. Хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэхэд болон орлогоо нэмэгдүүлэхэд байцаагчийн орон тоог 1 жилийн хугацаатайгаар гэрээт ажилтан нэмэх нь зүйтэй гэж үзэж байна. Нийт орон тоог 10-н хүнээр батлан тогтоов .


ТУЗ-н гишүүн: Д. Болдбаяр –Бүтэц орон тоо болон цалин хөлсийн нэмэгдлийн талаар дэмжиж байна.


ТУЗ-н нарийн бичиг: Насанжаргал – дэмжиж байна

Төхижилт үйлчилгээний албаны дарга Д. Ганцоож – дэмжиж байна.

ИТХурлын дарга: Б. Ганбаяр- Сумаас дэмжиж ажиллана.

Хэвсралтаар – бүтэц орон тоо болон цалин хөлсийн нэмэгдлийг харуулав.

ЖУРЛЫН ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  **Н. ГҮРРАГЧАА**

ЖУРЛЫН ПОРТКОЛ ХӨТӨЛСӨН:  **Г. НАСАНЖАРГАЛ**

Хавсралт-1

Бүтэц орон тоо, батлагдсан цалин

№	Албан тушаал	Орон тоо	Батлагдсан цалин
1	Дарга	1	750,000
2	Нягтлан бодогч	1	660,000
3	Нярав	1	660,000
4	Жолооч	2	610,000
5	Ковш оператор	1	610,000
6	Ачигч	2	567,000
7	Зам цэвэрлэгч	1	567,000
8	Байцаагч	1	618,000
Нийт		10	5,652,000